

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2026 оны 03 дугаар сарын 18

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажил	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Төсөв /мян.төг/	Хэрэгжилт
Нэг. Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх						
1	Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх	1.Журамд заасан богино болон дунд хугацааны сургалт, мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг хамруулах	Чанар: хууль, журамд заасан шаардлагыг хангасан албан хаагчдыг хамруулж мэргэшүүлсэн байх	Албан хаагчдын ур чадварыг дэмжиж, дээшлүүлсэн байна.		Газрын даргын 2025 оны Б/73 дугаар тушаалын дагуу 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл долоо хоног бүрийн ажлын 1 өдөр чөлөө олгож сурах нөхцөлийг бүрдүүлсэн. Удирдлагын академийн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2 албан хаагч хамрагдаж, Удирдлагын академийн захирлын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/141 тоот тушаалаар R2790, 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/312 тоот тушаалаар R3043 сертификатыг тус тус авсан. Удирдлагын академийн төрийн захиргааны тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх дунд хугацааны багц сургалтад 1 албан хаагч хамрагдах хүсэлтэй байгааг уламжлан газрын даргын 2025 оны 01/01/1798 дугаартай бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажилласан.
		2. Албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулах	Чанар: Сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлон чадавхийг дээшлүүлсэн байх			Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс зохион байгуулагдах сургалтад төлөвлөгөөний дагуу 50 албан хаагч хамруулсан. Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”, Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн боловсролын газартай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 02 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл 09:00-13:30 цагийн хооронд гурван ээлжээр 12 удаагийн 90 албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулж 88 албан хаагчдад Нийслэлийн Боловсролын газраас сертификат олгосон. Мөн Нийслэлийн Архивын газар Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр “Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх” сэдэвт сургалтад 10 албан хаагчийг хамруулсан байна.

					<p>Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Монгол бичгийн цахим бичвэр сургалтад 11 албан хаагч, ТАХ-ийн ёс зүйн тухай хууль, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад нийт 7 албан хаагч, Нийслэлийн түүх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүтэц, чиг үүрэг сургалтад нийт 7 албан хаагч, Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх сургалтад нийт 9 албан хаагч, Мониторингийн хяналт, үр дүнгийн үнэлгээ: Мэдээлэл бэлтгэх, тайлан боловсруулах ур чадвар сургалтад нийт 10 албан хаагч, Өргөдөл гомдлын системийн хэрэглээ сургалтад нийт 3 албан хаагч, Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, аргачлал сургалтад нийт 2 албан хаагч, Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, аргачлал сургалтад нийт 2 албан хаагч, Мониторингийн хяналт, үр дүнгийн үнэлгээ: Байгууллагын хяналтын тогтолцоо, сургалтад нийт 1 албан хаагч, Сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлэн ашиглах нь сургалтад нийт 4 албан хаагч, POWER BI ДАШБОАРДАД ШИЛЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ сургалтад нийт 2 албан хаагч, ERP системийн хэрэглээ сургалтад нийт 2 албан хаагч, Ажлын байр ба баг хамт олны үр дүнтэй харилцаа сургалтад нийт 2 албан хаагч, Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй сургалтад нийт 8 албан хаагч, Стресс менежмент сургалтад нийт 3 албан хаагч тус тус давхардсан тоогоор хамрагдсан.</p> <p>Албан хаагч нарыг 2025 оны 09 дүгээр сарын 23-нд Автотээврийн салбарын гавьяат тээвэрчин, доктор Л.Түдэвийн Бүтээлч оюун ухаан, шинжлэх ухааны тухай сургалтад хамруулсан.</p>
		<p>3.Гадаад, дотоодын байгууллагаас зохион байгуулж буй мэргэшүүлэх сургалтад хамруулах</p>	<p>Чанар: Гадаад орны арга туршлагаас суралцах, мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн байх</p>		<p>Газрын даргын “Гадаадад томилолтоор ажиллуулах тухай” 2025 оны А/06 дугаар тушаалаар Япон улсад Жайка ОУЛсын байгууллагаас зохион байгуулагдах “Хотын нийтийн тээвэр 202311602J001”-сургалтад 1 албан хаагч, А/79 дүгээр тушаалын дагуу Австри улсын Грац, Вена хотуудад зохион байгуулагдах “Тогтвортой хотын тээврийн чадавх бэхжүүлэх” семинарт оролцуулах 1 албан хаагчийн саналыг тус тус хүргүүлсэн.</p> <p>Мөн газрын даргын А/53 дугаар тушаалаар 2 албан хаагч АНУЛсын Прово муж дахь Бригам Янгийн Их сургуулийн Жорж В.Ромнигийн нэрэмжит Төр нийтийн үйлчилгээ, ёс зүйн</p>

					сургуулиас “Төр, нийтийн удирдлагын хөтөлбөр”-т хамрагдсан. А/94 дүгээр тушаалаар 2 албан хаагч Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зохион байгуулагдсан “Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ухаалаг, дижитал хотын тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах төслийн эхний чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-т хамрагдсан. А/130 дугаар тушаалаар 1 албан хаагч Монгол Улс, БНХАУ-ын дипломат харилцаа тогтоосны 76 жилийн ойн хүрээнд УБ болон Чунчин ах дүү хотын найрамдалт харилцааг бэхжүүлэх зорилгоор Чунчин хотод “Нийтийн тээврийн үйл ажиллагаатай танилцав.
	4. Холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын сургалтад хамруулах, зохион байгуулах	Чанар: Албан хаагчдад хуулийн мэдлэг олгосон байх	Хуулийн зүйл заалт, журмыг хэрэгжүүлж ажилласан байна		Албан хаагчдын ёс зүйн үүрэг хариуцлага, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний бүрэн эрх, албан үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэл, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргийн хэрэгжилтийг хангуулах талаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Тус газрын даргын шийдвэрээр төрийн захиргааны албан хаагчдад болон Хяналт шалгалтын хэлтсийн удирдлага, автотээврийн хяналтын улсын байцаагч нарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг нэг бүрчлэн хүргүүлж судлуулав.
	5. Албан хаагчдыг бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, суралцах бололцоогоор хангах /докторант, магистрт сурах/	Чанар: Доктор, магистрын боловсролын хөтөлбөрийг дуусгасан байх	Боловсролын зэрэг өндөртэй албан хаагчид нэмэгдсэн байна.	-	Тус газрын 1 албан хаагчид докторын дараах сургалтын судалгааны ажлыг үргэлжлүүлэх зорилгоор урт хугацаанд суралцах үед чөлөө олгон суралцах боломжоор ханган газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Б/217 дугаар тушаалаар зөвлөх инженерийн нэмэгдлийг олгож эхэлсэн.

Хоёр. Албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчинг бүрдүүлэх

2	Албан хаагчдын ажиллах таатай орчинг бүрдүүлэх	1.Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээг өдөр бүр тогтмол хийлгэх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх	Чанар: Эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллуулсан байх	Албан хаагчдын ажиллах цэвэр орчин, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлсэн байна.	-	<p>Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газартай хамтран ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгүүлж албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчныг бүрдүүлэх, цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан.</p> <p>Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд: Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газраас 31 албан хаагч 03 дугаар сарын 28-ны өдрийн 11:00-14:00 цагийн хооронд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас ирүүлсэн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хуваарийн дагуу Төв бассейнаас Бээжингийн гудамж хүртэл Сэлбэ голын баруун талын зам дагуу 1000 м.кв нийтийн эзэмшлийн зам талбайд хуримтлагдсан ил задгай хог хаягдлыг ачих, шон дээр наасан зарлал наалтыг хуулах, автобусны буудал түүний ойр орчим нийтийн эзэмшлийн эд хогшил, хайс, хашлага, мод бут, зам талбайг цэвэрлэж ажиллаа. Нийт цэвэрлэгээний материал /шуудай, ажлын бээлий, шүүр, савар/ зэргийг ашиглан 18 шуудай хог хаягдал цэвэрлэсэн.</p> <p>“Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 44, “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” 2021 оны 178 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нийтэд сурталчилж, мод тарьж, арчлан ургуулах ажлыг орон даяар зохион байгуулах зорилгын хүрээнд хаврын мод тарих арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын нийт албан хаагчид “Ногоон хот Иргэний оролцоо” уриатайгаар Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Баянгол цэцэрлэгт хүрээлэнд 80 хайлаас, 10 монос, 5 голт бор модыг, 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр албан хаагчдын өгсөн хандиваар 74 хайлаас, 21 улиас модыг тус тус тарьсан.</p>
		1.Компьютер, хэвлэгч, суурин утас бусад шаардлагатай техник хэрэгслээр хангах, цахим	Чанар: Албан хаагчид ажиллах нөхцөлөөр хангагдаж, ажлын бүтээмж, үр дүн	Албан хаагчид ажлын бүтээмж дээшлэн үр дүнтэй ажилласан байна.	-	Тус газрын албан хаагчид компьютер, хэвлэгч, суурин утас болон бусад шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангагдсан ба цахим сүлжээнд холбож, албан ажлын хэрэгцээнд шаардлагатай программ хангамжийг суурилуулан ашиглах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

		сүлжээнд бүрэн холбох, албан ажлын хэрэгцээнд шаардлагатай програмуудыг суулгаж өгөх	дээшилсэн байна.			Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1/1814 дугаартай Хөрөнгө бүртгэх тухай албан бичгийн дагуу компьютер, принтер, тавилга, эд хогшлыг бүртгэсэн.
		2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх	Чанар: Болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, багаж хэрэгслүүдийг стандартын дагуу байрлуулсан байх	Галын болон бусад болзошгүй аюулгүй байх нөхцөл бүрдсэн байна.	-	Галын болон болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд архивын өрөө болон бусад шаардлагатай өрөөнүүдэд галын хорыг байрлуулах, мэдээллийн самбар байрлуулан ажиллаж байна. Мөн архивын өрөөг Нийслэлийн нутгийн Захиргааны цогцолбор "Б" байрны В-1 давхарт байршуулах ажлыг гүйцэтгэн, "Галын аюулгүй байдлын дүгнэлт" гаргуулахаар 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/01/1134 дугаартай албан бичгээр Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэст хүргүүлсэн.
Гурав. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах, тэтгэмж тэтгэлэгт хамруулах						
3	Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр ажил зохион байгуулах	1.Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль эрх зүйн актууд, Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасан тэтгэмж, тусламжуудыг олгож дэмжлэг үзүүлэх	Чанар: Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль эрх зүйн актууд, Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасан тэтгэмж, тусламжуудыг олгож дэмжлэг үзүүлсэн байна.	Нийгмийн баталгааг хангах чиглэлээр холбогдох байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээг албан хаагчдад танилцуулж, хамрагдах боломж нөхцөлөөр хангасан байна.		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр батлуулж, газрын цахим хуудаст байршуулан албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд тус газраас орон сууцны хөтөлбөрт хамрагдах албан хаагчдын материалыг "Албан тушаалын орон сууцанд хамрагдсан оршин суугчдын дагаж мөрдөх журам"-ын дагуу бүрдүүлэн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/01/1295 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлснээс тус газрын 1 албан хаагч шалгарч тогтвортой ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бодитой дэмжлэг болох үүднээс Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатарын санаачилгаар Яармагийн хотын захиргаанаас алслагдсан байршилд амьдарч байгаа албан хаагчдын орон сууцны асуудлыг шийдэх зорилгоор эхний ээлжийн шаардлагатай байгаа 1 албан хаагчид Албан тушаалын орон сууц ашиглуулах батламж, түлхүүр гардуулан өгч улсын комисс хүлээн авч,

					<p>ашиглалтад орсон хотхонд түрээс төлөхгүйгээр амьдрах таатай нөхцөл бүрдсэн байна.</p> <p>Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны А/64 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын дагуу албан хаагч нарт тухай бүрт тушаал гарган олговортой чөлөө, буцалтгүй тусламж, тэтгэмжийг олгон ажилласан.</p>
	2. Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах	Чанар: Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан үр дүнг тайлагнасан байх	Аливаа өвчнөөс урьдчилан сэргийлсэн байна.		<p>Нийтийн тээврийн бодлогын газрын албан хаагчдын дунд томуугийн улирлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, байгууллагын ажлын тасралтгүй байдлыг хангах зорилгоор 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр томуугийн вакцинжуулалтын ажлыг зохион байгуулсан.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсаас нийлүүлэгдсэн томуугийн вакциныг ашиглан байгууллагын нийт албан хаагчдыг хамруулах санал асуулгыг зохион байгуулж, сайн дурын үндсэн дээр дархлаажуулалтад хамрагдах ажилтнуудыг бүртгэлжүүлэн ажиллав.Тус томуугийн вакцинжуулалтанд нийт 12 албан хаагч хамрагдсан.</p>
	3. Хүүхдийн баяр, шинэ жилийн баярыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд баяр хүргэх, тэдний дунд арга хэмжээ зохион байгуулах	Чанар: Дотоод журамд заасан заалтуудыг төсвийн хүрээнд хэрэгжүүлж ажилласан байх	Дотоод журмын заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.		<p>Тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийт алба хаагчдын 0-18 насны 181 хүүхдэд хүндэтгэл үзүүлэн ажилласан байна.</p>
	4. Ахмадын баяр болон сар шинийн баяраар ахмад настнуудыг хүлээн авах ажлыг зохион байгуулах	Чанар: Ахмадын баярын өдөр болон сар шинийн баярыг тохиолдуулан ахмад настнуудад хүдэтгэл үзүүлэх	Дотоод журмын заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.		<p>Тус газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/14 дүгээр тушаалын дагуу Монгол түмний уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын ахмадуудад хүндэтгэл үзүүлж тус бүрт нь 30,000 төгрөгийн урамшуулал олгосон.</p> <p>Нийтийн тээврийн салбарын 3 үеийн чуулга уулзалт сургалтыг зохион байгуулахаар 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/70 дугаар тушаалын дагуу ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 07 дугаар сарын 18,19-ний өдрүүдэд зохион байгуулсан.</p>

						<p>2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/95 дугаар тушаалын дагуу Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсэн.</p> <p>Энэхүү арга хэмжээний хүрээнд ахмадуудад Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёслолын танхимтай танилцуулж, дурсгалын зураг даруулан, тус бүрт нь 100,000 төгрөгийн урамшуулал олгож хүндэтгэл үзүүлсэн.</p> <p>2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/131 дугаар тушаалын дагуу Ахмадын хороо төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал, туслах ажилтан нартай байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу тооцон цалин урамшуулал, байнгын эмчилгээ, сувилгаа асаргаанд байгаа ахмад настнуудад мөнгөн тусламж, нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмадуудад түлш худалдан авахад нь зориулан мөнгөн тусламжийг тус тус олгосон.</p> <p>2025 онд 2 ахмадыг тус газрын даргын тушаалаар ахмадын бүртгэлд авсан.</p> <p>2025 онд 6 албан хаагч тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж, ажлаас чөлөөлөгдөж, буцалтгүй тусламж авсан.</p>
Дөрөв. Албан хаагчдын цалин хөлс, урамшууллыг ажлын үр дүнгээр олгох, шагнаж урамшуулах						
4	Албан хаагчдын цалин хөлсний нэмэгдэл, урамшуулах, шагнах ажлыг зохион байгуулах	1.Хууль, тогтоомжийн дагуу албан хаагчдын цалин хөлс, зэрэг, дэвийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох	Чанар: Хууль тогтоомжид заасан нэмэгдлийг тооцон хэрэгжүүлж ажиллах	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.		<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын дагуу газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын Б/05 дугаар тушаалаар байгууллагын нийт албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд өөрчлөлт оруулсан.</p> <p>2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг баримтлан ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/578 дугаар захирамжийн дагуу 7 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгосон.</p>
		2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр үнэлэх ажлыг зохион	Чанар: Үнэлгээнд үндэслэн урамшуулалт цалин олгох, цалингийн шатлал ахиулах	Гүйцэтгэлд суурилсан чадварлаг, тогтвор суурьшилтай		<p>Тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Үнэлгээний баг байгуулах тухай А/62 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар үнэлгээний багийн ажиллах журмыг батлан, газрын албан хаагчдын 2025 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн гүйцэтгэлийг үнэлж дүгнэн төрийн</p>

		байгуулах, үнэлгээнд үндэслэн арга хэмжээг авах		хүний нөөц бий болгосон байна.		албан хаагчдад ажлын үр дүнгээр Б/99 болон Б/223 дугаар тушаалаар тус тус мөнгөн урамшуулал олгосон.
		3. Ажлын үр дүнгээр албан хаагчдыг шагнаж, урамшуулах ажлыг зохон байгуулах	Чана: Төрийн болон бусад шагналд тодорхойлсон байх	Тогтвор суурьшилтай хүний нөөц бий болгосон байна.		<p>Автотээврийн салбарын 100 жилийн ойг угтаж Автотээврийн салбарт идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, ажил хөдөлмөрөөрөө тэргүүлж, хамт олноо манлайлан ажилласан тус газрын нэр бүхий албан хаагчдыг дараах шагналуудад нэр дэвшүүлэн дээд газар холбогдох материалуудыг хүргүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1." Гавьяат тээвэрчин"-оор 1; 2."Цэргийн гавьяаны одон"-оор 1; 3."Алтан гадас одон"-оор 1; 4."Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар 15; 5.Сангийн яамны "Санхүү, банкны тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр 1; 6. Сангийн яамны "Жуух бичиг"-ээр 1, 7.Зам, тээврийн хөгжлийн яамны "Жуух бичиг"-ээр 3, 8."Автотээврийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр 4, 9."Нийслэлийн тэргүүний ажилтан" цол, тэмдгээр 6; 10. "Нийслэлийн хүндэт тэмдэг"-ээр 5; 11.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн "Жуух бичиг"-ээр 9; 12.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт үнэмлэх"-ээр 3; 13.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт тэмдэг"-ээр 5; 14.Тээврийн Цагдаагийн албаны "Осолгүй манлай жолооч" тэмдгээр 1 албан хаагч, нийт 56 албан хаагчийг шагнуулахаар холбогдох байгууллагуудад материалыг хүргүүлсэн. Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын хүрээнд, хариуцсан ажилдаа идэвхи зүтгэл гарган, бүтээлч хандлагаар ажил хөдөлмөрөө үнэлүүлж, хамт олноо манлайлан, улс орны хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулсан дараах нэр бүхий албан хаагчдыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шагнаж урамшуулсан. Үүнд: 1."Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-оор 1; 2." Зам тээврийн яамны "хүндэт жуух бичиг"-ээр 1; 3. "Нийслэлийн хүндэт тэмдэг"-ээр 6; 4. "Нийслэлийн тэргүүний ажилтан" цол, тэмдгээр 5; 5. "Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын

					<p>захирагчийн “жуух бичиг”-ээр 9; 6. “Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын “хүндэт үнэмлэх”-ээр 3; 7.Зам, тээврийн хөгжлийн яамны “Жуух бичиг”-ээр 3, 8.“ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын “хүндэт тэмдэг”-ээр 5; 9. “Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын “хүндэт өргөмжлөл”-ээр3; 10. “Нийслэлийн хүндэт тэмдэг”-ээр 5; 11.Тээврийн Цагдаагийн албаны "Осолгүй манлай жолооч" тэмдгээр 1 албан хаагч, нийт 33 албан хаагч, Автотээврийн салбарын 100 жилийн ойн медалиар 130 албан хаагчийг шагнасан. 2025 онд ажил мэргэжлээрээ тэргүүлсэн ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын хүндэт дэвтэрт бичигдэх-3 2. Байгууллагын хөдөлмөрийн аварга-1 3. Шилдэг ажилтан-4 4. Хэлтсийн аварга-8 5. Онцлох ажилтан-15
Тав. Хүний нөөцийн мэдээллийн санг шинэчлэн баяжуулах					
5	Хүний нөөцийн системд бүрэлдэхүүн хөдөлгөөнийг шинэчлэх	1.Хүний нөөцийн цахим системд бүрэлдэхүүн хөдөлгөөн, албан хаагчтай холбоотой мэдээллийг тухай бүр шинэчлэх	Чанар: Сургах, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах, ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл бүрдүүлсэн байх	Хүний нөөцтэй холбоотой аливаа мэдээлэл үнэн зөв, шийдвэр оновчтой гарсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ шинэчлэн батлагдсантай. Үүнтэй холбогдуулан тус газрын даргын 2025 оны Албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэн батлах тухай Б/05 дугаар тушаал батлагдан, “Хүний нөөцийн нэгдсэн систем”-д 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр 174 албан хаагчдын цалинд өөрчлөлт оруулсан. Шинээр томилогдсон болон, чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг тухай бүрд шинэчлэн ажилласан. Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албаны “Хүний нөөцийн нэгдсэн систем” цахим системд дэх төрийн албан хаагчийн мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт болгон 165 баталгаажуулалтыг хийж ажилласан.
		2. Хүний нөөцийн мэдээллийн	Чанар: Хувь хүний нууцыг	Хуулийг хэрэгжүүлж	Хүний нөөцийн мэдээллийн сангийн нууцлалыг хадгалах, хангах үүднээс цахим системийн түлхүүр нууц үгийг улирал бүр шинэчлэн өөрчилж ажилласан.

		системийн нууцлалыг хангах	чандлан хадгалсан байх	ажилласан байна.		
Зургаа. Хүний нөөцийг эрсдлийн удирдлагаар хангах						
6	Хүний нөөцийг эрсдлийн удирдлагаар хангах	1.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг албан хаагчдад таниулах	Чанар: Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний мэдээллийг албан хаагчдад танилцуулсан байх	Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, газрын цахим хуудаст байршуулан албан хаагчдад танилцуулсан.
		2. Албан хаагчдын ажлын ачааллыг судлах, ачааллыг тэнцвэржүүлэх ажлыг зохион байгуулах	Чанар: Ажлын ачаалал тэнцвэржиж ачаалалгүй ажилласан байх	Ажлын ачааллыг тэнцвэржүүлсэн байна.		Албан хаагчдын ажлын ачааллыг судлах, ачааллыг тэнцвэржүүлэх ажлыг зохион байгуулах ажлыг судлан ажлын байрны тодорхойлолт тусган, хэлтэс нэгжийн дарга нар дотоод зохион байгуулалтаа сайжруулан ажиллаж байна. Мөн сул орон тоонд өөр байгууллагаас төрийн захиргааны 3 албан хаагчийг шилжүүлэн томилон ажиллуулсан.
Долоо. Байгууллагын соёлыг хөгжүүлэх						
7	Байгууллагын соёлыг хөгжүүлэх	1.Байгууллагын соёлыг бэхжүүлэх үүднээс урлаг, спорт, соёлын арга хэмжээг зохион байгуулах, албан хаагчдын хандлага, дадал, чадвар, соёл, сонирхлын байдлыг харгалзан	Чанар: Сар бүр идэвхжүүлэлтийн ажил зохион байгуулсан байх	Хамт олны идэвх санаачлагыг дээшлүүлсэн байна.		Байгууллагын соёл урлаг спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх үүднээс тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Спорт тэмцээн зохион байгуулах тухай” А/57 дүгээр тушаал батлагдан 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгууллагын спортын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан. Мөн автотээврийн салбарын 100 жилийн ойн хүрээнд салбарын спортын аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд зохион байгуулагдан тус газрын дардасны эрэгтэй, эмэгтэй баг тус бүр мөнгөн медаль авсан байна. УРАН ЖОЛООДЛОГО-2025 тэмцээнийг 2025 оны 06 дугаар сарын 07,08-ны өдөр Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын Хүй долоо худаг дахь талбайд зохион байгуулсан. Энэ

		мэдээлийн цагийг тогтмол чвуулах				удаагийн тэмцээнд нийт 14 байгууллагын 14 багийн нийт 69 жолооч хурд хүч, авхаалж самбаа, мэдлэг, ур чадвараа сорин өрсөлдсөн. Явган аялалыг тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/55 дугаар тушаалаар батлуулж, 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, автотээврийн салбарт үйлчилгээ эрхлэгч 15 аж ахуй нэгж байгууллагын 75 тамирчин ажилттай оролцсон. Богдхан-Уулын ноён оргил Цэцээ гүн нь далайн түвшнээс дээш 2257 м өндөрт байрладаг бөгөөд оргилд гарсан.
Найм. Хүний нөөцийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг бүрдүүлэх						
8	Хүний нөөцийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах	1.Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэнэ.	Чанар: Сул орон тоо иргэд, олон нийтэд хүрсэн байх	Сул орон тооны мэдээлэл иргэд, олон нийтэд нээлттэй болосон байна.		Тус газарт үүссэн сул орон тооны мэдээллийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/01/35, 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01/01/872, 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/01/885 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. Сул орон тооны зарыг тухай бүр шинэчлэн https://www.transport.ub.gov.mn/p/27 цахим хуудсанд байрлуулан ажиллаж, пэйж хуудсаар олон нийтэд түгээж ажилласан. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр тус газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд хамаарах сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг нээлттэй зарлан, тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, ерөнхий шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн иргэдийг тусгай шалгалтад оролцохыг урьж байгууллагын цахим хуудсанд зар мэдээллийг байршуулан ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр тусгай шалгалтад оролцогчдоос нийт 21 хүн тэнцсэнээс манай газраас 12 албан хаагч тэнцсэнээс 11 албан хаагч төрийн захиргааны албан тушаалд, гаднаас 9 хүн тэнцсэнээс 4 хүн төрийн захиргааны албан тушаалд тус тус томилогдсон.
		2. Хүний нөөцийн хөтөлбөр түүний хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх	Чанар: Хүний нөөцийн хөтөлбөр түүний хэрэгжилт олон нийтэд хүрсэн байх	Хүний нөөцийн хөтөлбөр түүний хэрэгжилт олон нийтэд нээлттэй		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан баталж газрын цахим хуудаст байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.

		ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулах		мэдээлэгдсэн байна.		
		3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж, цахим хуудсанд байрлуулна.	Чанар: Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм олон нийтэд хүрсэн байх	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм олон нийтэд нээлттэй мэдээлэгдсэн байна.		Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан ёс зүйн дүрэм болон байгууллагын дотоод ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд тус газрын даргын 2025 оны “Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай” А/02 дугаар тушаалаар байгуулагдсан бүрэлдэхүүн хяналт тавин ажиллаж. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/86 дугаар тушаалаар ёс зүйн дэд хорооны 2 гишүүн төрийн албанаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан алба хаагчдаас олонхын санал авсан Хуулийн хэлтсийн хууль тогтоомж судлаач 2 албан хаагчийг нөхөн томилсон.

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР